



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны хоёрдугаар байрыг Худалдааны төлөөлөгчийн газар, Соёлын төвийн зориулалтаар ашиглахад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Д.Амарсайхан  
/зөвшилцсөнөөр/

Гишүүд: Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа ЭСЯ-ны элчин зөвлөх Д.Өнөбилэгт  
/зөвшилцсөнөөр/

Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын атташе А.Баярсайхан  
/зөвшилцсөнөөр/

Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч Г.Баярмаа  
/зөвшилцсөнөөр/

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын хяналтын ерөнхий инженер, ахлах мэргэжилтэн Д.Цэнд  
/зөвшилцсөнөөр/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн  
мэргэжилтэн М.Баярмаа


Нарийн бичиг:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн  
мэргэжилтэн М.Гэрэлмаа

2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтыг 2023 оны 2 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 02 дугаар сарын 13 өдрийн  
А/15 дугаар тушаалын хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны хоёрдугаар байрыг Худалдааны төлөөлөгчийн газар, Соёлын төвийн зориулалтаар ашиглахад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны хоёрдугаар байрыг Худалдааны төлөөлөгчийн газар, Соёлын төвийн зориулалтаар ашиглахад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2. Нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнг 2023 оны 2 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулана.

-----000-----